



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1.Аймгийн Засаг даргын Шуурхай хуралд батлагдсан дэгийн дагуу хуралдаа оролцох. Орлон ирж байгаа албан тушаалтан тодорхой мэдээлэлтэй, хувцаслалтад анхаарах, шуурхай хурлаас чөлөө авах асуудлыг дэгийн дагуу авч байх, чөлөө аваагүй тохиолдолд хариуцлага тооцон ажиллах.

Хугацаа: Тухай бүрд

НАЙРАМДАА - ДРЧЖБА



Биелэлт:

Байгууллагуудад үүрэг даалгаврыг хүргүүлсэн бөгөөд хэлтэс, алба, газрын дарга нар албан хаагчдадаа мэдээлэл өгсөн.

Хэрэгжилт: Бүрэн хэрэгжсэн.





2. Шинээр баригдаж байгаа орон сууцыг дуусаагүй байхад улсын комисс ажиллуулж байгаа асуудлыг таслан зогсоох холбогдох дүрэм журмын хүрээнд ажлыг зохион байгуулах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт:ГХБХБГ

- Дуусаагүй орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажил зохион байгуулагдаагүй болно. Тухайн барилга байгууламжийн ажил дуусч захиалагч, зохиогчийн хяналт гүйцэтгэгч байгууллагуудын “Ашиглалтад оруулах боломжтой” гэсэн нэгдсэн дүгнэлтийг үндэслэн Барилгын тухай хуулийн 48.5 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдэл, гүйцэтгэлийг үндэслэн улсын комисс ажиллуулах хүсэлтийг шийдвэрлэж байна.
- 2-3 блок баригдахаар төлөвлөгдсөн барилга байгууламжийг Барилгын тухай хуулийн 48.4 дүгээр зүйлд заасан “Цогцолбор барилга байгууламжийн технологийн хувьд нэгдмэл бус бүрдэл хэсгийг хэсэгчлэн энэ хуулийн 48.1-д зааснаар ашиглалтад оруулж болно” гэсэн заалтыг үндэслэн тухайн блок барилга, түүнд харьяалагдах гадна тохижилтыг гүйцэтгэсний дараа ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



3. Жаргалант сумын төмс хүнсний ногооны зоорины ашиглалтын зардлыг тооцож танилцуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: Жаргалант сумын ЗДТГ

Жаргалант сумын төмс хүнсний ногооны зоорины цахилгааны зардал 2024 оны 11 дүгээр сард 3420.6 мянган төгрөг, 12 дугаар сард 5530.4 мянган төгрөг гарсныг аймгийн Засаг даргад танилцуулсан.

Хэрэгжилт: Бүрэн хэрэгжсэн.





4. 17-р сургуулийн халаалтын нийт зардал тооцоог гаргаж танилцуулах. Цаашдаа тухайн ойр орчмын төрийн байгууллага, аж ахуй нэгжүүдийг холбох асуудлыг судлан танилцуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХЗА

17-р сургуулийн халаалтын зуухыг газан зуухаар солих ажлыг төлөвлөхдөө Даваат багт байгаа сургуулийн 2 барилга, Соёлын төв, халуун ус, багийн байр, ус түгээх байр, эмнэлэг, цэцэрлэгийн барилгууд болон нэмэлтээр барилга барихаар тооцож 1400квт-ын хүчин чадалтай газан зуухыг суурилуулсан.

Одоогийн байдлаар дээрх барилгуудыг 630квт-аар халааж байгаа 3 зуух өвлийн оргил ачааллын үед хоногт 480 кг газ зарцуулж, 1.3 сая төгрөг, 1 сард 13824 кг газ зарцуулж, 38.7 сая төгрөгийн зардал гарахаар тооцоо гарсан.

Цаашид өрхийн эрүүл мэндийн төв болон цэцэрлэгийн барилгыг нэмж холбох, шинээр барилга барихад 7 газан зуухыг бүрэн ажиллуулах боломжтой. Одоогийн байдлаар 27523м³ эзлэхүүнтэй 5 барилгыг 3 зуухаар 8 сарын хугацаанд халаахад 110592кг газ зарцуулж, 309.7 сая төгрөгийн зардал гарах тооцоо гараад байна.

Хэрэгжилт: Бүрэн хэрэгжсэн.



5. Барилга байгууламж барих ажлын үеэр зөвшөөрөлгүй асгаж буй барилгын шорооны асуудалд онцгой анхаарч зөвшөөрөл аваагүй цэгт асгасан аж ахуй нэгжүүдэд хариуцлага тооцох.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

2024 онд 13 аж ахуйн нэгж, байгууллагад барилгын суурийн шороо зөөвөрлөх цэгийн зөвшөөрлийг олгосон. Ингэснээр зөвшөөрөлгүй цэгт шороо асгах зөрчил гараагүй болно.

Хэрэгжилт: Бүрэн хэрэгжсэн.





6. Шинэ жилийн баярын өдрүүдэд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангуулах талаар эргүүл, шалгалтуудыг эрчимжүүлж иргэдэд сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл олон нийтийн сувгаар тогтмол хүргүүлэх. /Сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмжүүдийн нөөц бүрдүүлэх, шуурхай ажлын хэсгүүдийн бэлэн байдлыг хангах холбогдох албан хаагчдыг үүрэгжүүлэх, хариуцах утсыг тодорхой болгох байгууллагуудын дарга нарын утас нээлттэй бэлэн байх/

Хугацаа: Тухай бүрд



Биелэлт: ЭМГ

Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2024 оны А/597 дугаар захирамжийн дагуу ЭМГ-ын даргын А/114 дүгээр тушаалаар шинэ жилийн баярын үеэр нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дуудагдан ажиллах албан хаагчид, хариуцлагатай жижүүрийг томилон үүрэгжүүлж, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган, эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй шуурхай үзүүлэхийг бүх шатны захирал, дарга нарт үүрэг болгож, тусламж үйлчилгээний бэлэн байдал, үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Хэрэгжилт: Бүрэн хэрэгжсэн.

НАЙРАМДАА - ДЭМЖИД



Биелэлт: ЦГ

Шинэ жилийн баярын өдрүүдэд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр бүр 11:00-15:00 цагийн хооронд томоохон зах, худалдааны төвүүдэд 2 чиглэлд 4 алба хаагч, 23:00-03:00 цагийн хооронд гудамж, талбай олон нийтийн газарт 14 чиглэлд 28 алба хаагч, авто эргүүлийн 3 чиглэлд 6 алба хаагч иргэн, байгууллагаас ирүүлсэн дуудлага, мэдээлэл хүлээн авч ажилласан. Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэгт шилжүүлэн ажиллуулах тухай тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрүүдэд 40 алба хаагчдыг эргүүл шалгалтад татан оролцуулсан.

А.Амарын талбайд зохион байгуулсан шинэ оноо угтах арга хэмжээний үеэр Цагдаагийн газраас нийт 92 алба хаагч гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний болон олон нийтийн аюулгүй байдлыг ханган, зөрчил дутагдалгүй үүрэг гүйцэтгэн ажилласан.

Хэрэгжилт: Бүрэн хэрэгжсэн.



Биелэлт: ОБГ

Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль, аймгийн Засаг дарга, Онцгой байдлын ерөнхий газраас өгсөн үүрэг чиглэлийг хангах ажлын хүрээнд шинэ жилийн баярын үйл ажиллагааг зохион байгуулах, тэмдэглэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах, үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллага, томоохон худалдааны төв, захуудад пиротехникийн хэрэгсэл ашиглах, худалдан борлуулж байгаа байдалд хяналт тавих зорилгоор төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хүн олноор цугладаг 11 томоохон худалдааны зах, 3 үзвэр үйлчилгээний газар, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 7 ресторан, лоунж зэрэг нийт 21 объектод зохион байгуулж ажилласан.






Биелэлт: ОБГ

Цахилгаан эрчим хүчний хэт ачааллаас гарах гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, пиротехникийн хэрэгслийг баталгаагүй, зөвшөөрөлгүй газраас худалдан авах нь эрүүл мэнд, өмч хөрөнгөд эрсдэл учруулах аюултай болон Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцдог талаарх зөвлөмж, мэдээллийг 1 сайт, 3 пэйж хуудсуудаар түгээж, 40 мянга гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн байна. Мөн дээрх үйл ажиллагаатай холбоотойгоор 10 төрлийн зөвлөмж постер бэлтгэж, FM радиогоор 2 удаа, мэдээлэл, сэрэмжлүүлгийг өгч ажилласан.

Хэрэгжилт: Бүрэн хэрэгжсэн.





7. Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд онцгой анхаарах. Үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн танилцуулах биелэлт ирүүлээгүй хугацаа хоцроосон асуудалд тухайн байгууллагын удирдлагад хариуцлага тооцох.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХШҮХ

Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөн 2024 оны байдлаар 51 удаа хуралдаж, 383 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг нэгтгэн ажиллаж байна. Тайланд онд хамгийн олон удаа давтагдаж өгөгдсөн үүрэг даалгавраас дурдвал:

- Гэр хорооллын эрчим хүчний уналтын асуудлыг шийдвэрлэх тухай 9 удаа
- Аймгийн хөдөө аж ахуйн болон хотын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж ажиллах (Инженерийн шугам сүлжээ, цахилгаан эрчим хүч, өвс тэжээлийн фонд бүрдүүлэх, түлшний мод гэх мэт) тухай 9 удаа
- Хотын дотор болон А1001, А1002 авто замын нөхөөсний ажлыг эрчимжүүлэх тухай 8 удаа
- 2024 онд Улсын болон орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн ажлыг яаралтай бэлэн болгох тухай 8 удаа
- 2025 оны төсвийн төсөлд онцгой анхаарч бэлтгэл ажлыг хангаж холбогдох хурлуудаар хэлэлцүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулах тухай 6 удаа
- Тендерийн ажлуудыг шуурхайлах тал дээр онцгой анхаарах тухай 5 удаа
- Хотын болон гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн асуудалд онцгой анхаарч асалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах тухай 5 удаа

НАЙРАМДАА - ДҮҮЖДА



Биелэлт: ХШҮХ

Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хугацаандаа тайлагнасан ирцийг хувиар харуулбал:

- 1-30 хувьтай 4 байгууллага
- 31-70 хувьтай 13 байгууллага
- 71-99 хувьтай 20 байгууллага
- 100 хувьтай 12 байгууллага байна.

Хугацаандаа тайлагнаагүй буюу хэрэгжилт оруулаагүй дараах 5 байгууллага байна.

- СӨХ-ны салбар зөвлөл - 8 удаа
- СӨХ-ны "Эв нэгдэл" салбар - 6 удаа
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 5 удаа
- Сэлэнгэ голын сав газрын захиргаа - 2 удаа
- Нийтлэг үйлчилгээний алба - 1 удаа





8. Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгавар, хэрэгжилтийг тухай бүрт хэрэгжүүлэхэд анхаарах. А1001 авто замын хашлага, Жаст ойл ШТС-аас хорооллын эцэс өгсөх зам дагуу 28 дугаар цэцэрлэгийн баруун талын хашлагуудыг засварлах арга хэмжээг авч, буруутай этгээдэд хариуцлага тооцох.

Хугацаа: Ойрын хугацаанд

НАЙРАМДАА - ДУУЖДА



Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Цагдаагийн газарт албан бичиг хүргүүлж, хашлага, хаалт эвдсэн эзэн холбогдогчийг олж тогтоон хохирлыг төлүүлэхээр үнэлгээ хийгдэж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хуралдсан Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс 8 үүрэг даалгавар өгөгдсөн. Үүнээс:

- Бүрэн хэрэгжсэн 5
- Хэрэгжиж байгаа 3





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАЛ-ДРУЖБА